Дорноговь салбар АУС-ийн танхим болон цахим сургалтын SWOT үнэлгээг харьцуулсан нь

Ш.Энхмаа[1], Г.Мөнхтуяа[1]

[1]АШУҮИС, Дорноговь АУС
Цахим шуудан; enkhmaa@mnums.edu.mn, Утас: 91002989

Түлхүүр үг:

Хосолсон сургалт
Цахим хэрэглэгдэхүүн
Давуу тал
Сул тал

Товч утга:

Үндэслэл: 20-р зууны дунд үе хүртэл дэлхий нийтээр боловсролын үйлчилгээг танхимын сургалтын хэлбэрээр голчлон хүлээн авч байсан цаг үе ард үлдэж 21-р зуун буюу мэдээлэл технологийн хурдацтай хөгжлийн эрин үед боловсрол төдийгүй нийгмийн бүхий л салбарт интернэт, цахим платформыг ашиглан сургалт болон аливаа үйл ажиллагааг явуулах боломж бүрдэж байна.[1] Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан бүхий л шатны боловсролын үйлчилгээнд орчин үеийн мэдээлэл технологийн дэвшилд суурилсан цахим болон танхимын хосолсон хэлбэрийг нэвтрүүлэх хэрэгцээ улам бүр нэмэгдсээр байна.[2] **Зорилго:** Танхимын болон цахим сургалтын SWOT үнэлгээг харьцуулан судлах**. Арга, аргачлал:** Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн багш нараас Google Form судалгааны платформ ашиглан асуумж авч боловсруулалтыг EXCEL программ ашиглан хийлээ. **Үр дүн:** Цахим сургалтын SWOT үнэлгээ хийхэд хөл хорионы үед сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулж жил алдаагүй нь маш чухал байсан. Үүнээс гадна багш хаанаас ч хичээлээ удирдан явуулах боломжтой, боловсруулсан материалыг давтан ашиглах, цахим хэрэглэгдэхүүний шинэ мэдлэг олгосон, цахимаар суралцах шинэ сувгууд нээгдэн өөрийгөө хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлсэн зэрэг олон давуу талуудтай байсан. Цахим сургалтын үйл ажиллагаанд оюутнуудтай амьд харьцаа үүсгэхгүй, дадлагын хичээлийг гардан хийх боломжгүй байдаг нь хамгийн том сул тал юм гэсэн байна. Танхимын сургалтын дадлагын хичээлийг мэргэжлийн кабинет болон лабораторид удирдан явуулснаар багш суралцах үйл ажиллагааг өөрийн биеэр хянаж, үнэлгээг илүү бодитоор үнэлэх давуу талуудтай. **Дүгнэлт:** 1. Танхимын болон цахим сургалт нь аль аль нь өөрийн гэсэн давуу болон сул талуудтай бөгөөд SWOT үнэлгээ хийснээрээ цахим болон танхимын сургалтыг хослуулан ашиглах дараах боломж байна гэж дүгнэж байна. 2. Гардан ур чадвар шаардсан хичээлийг зайлшгүй танхимаар удирдан явуулах нь суралцагчдад бодит ур чадварыг эзэмшүүлэх, үнэлгээг бодитой хийн чадварлаг мэргэжилтнүүд бэлтгэх боломж олгож байна. Анагаахын мэргэжилтэн бэлтэх сургалтад дан цахим хэлбэрийн сургалт тохиромжгүй бөгөөд танхим болон цахим сургалтыг зохистойгоор хослуулон явуулах боломжтой.

Үндэслэл: 20-р зууны дунд үе хүртэл дэлхий нийтээр боловсролын үйлчилгээг танхимын сургалтын хэлбэрээр голчлон хүлээн авч байсан цаг үе ард үлдэж 21-р зуун буюу мэдээлэл технологийн хурдацтай хөгжлийн эрин үед боловсрол төдийгүй нийгмийн бүхий л салбарт интернэт, цахим платформыг ашиглан сургалт болон аливаа үйл ажиллагааг явуулах боломж бүрдэж байна.

Уламжлалт буюу танхимын сургалтын явцад хичээлийг төлөвлөх, лекц унших, тайлбарлах, зохион байгуулах, шалгах, үнэлэх зэргээр бүхий л үйл ажиллагааг багш удирддаг учир хичээлийн

үеэр оюутнууд сонсох, тэмдэглэл хөтлөх, асуултанд хариулах, шалгуулах, дүгнүүлэх зэргээр идэвхгүй үйлдлүүдийг голлон гүйцэтгэдэг. Харин цахим буюу зайн сургалтын явцад оюутан нэмэлт мэдээллийн эрэл хайгуул хийх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, сурах үйл явцаа төлөвлөх, өөрийн үнэлгээ хийх, эргэлзээтэй асуудлыг нягтлан судлах, асуулт бэлтгэх, багшаас зөвхөн тодруулга авах замаар хичээлд оролцдог.[1]

Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан бүхий л шатны боловсролын үйлчилгээнд орчин үеийн мэдээлэл технологийн дэвшилд суурилсан цахим болон танхимын хосолсон хэлбэрийг нэвтрүүлэх хэрэгцээ улам бүр нэмэгдсээр байна.[2]

Ковид 19 цар тахлын улмаас бид 2020-2021 оны сургалтандаа цахим сургалтыг ашигласан ба уламжлал болон ирсэн танхимын сургалт болон хэсэг хугацаанд хэрэгжүүлж байсан цахим сургалтын өнгөрсөн болон одоог дүгнэн харьцуулж SWOT үнэлгээ хийн цаашид сургалтын аль хэлбэрийг ашиглах нь үр өгөөжтэйг тодорхойлох шаардлагатай байна.

Зорилго: Танхимын болон цахим сургалтын SWOT үнэлгээг харьцуулан судлах

Зорилт:

1. Танхимын сургалтын SWOT үнэлгээг тодорхойлох
2. Цахим сургалтын SWOT үнэлгээг тодорхойлох

Арга, аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар АУС-ийн 22 багшаас Google Form судалгааны платформ ашиглан асуумж авч судалгааны боловсруулалтыг EXCEL программ ашиглан хийлээ.

Үр дүн: Цахим сургалтын SWOT үнэлгээ хийхэд хөл хорионы үед сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулж жил алдаагүй нь маш чухал байсан. Үүнээс гадна багш хаанаас ч хичээлээ удирдан явуулах боломжтой, боловсруулсан материалыг давтан ашиглах, цахим хэрэглэгдэхүүний шинэ мэдлэг олж авах, цахимаар суралцах шинэ сувгууд нээгдэн өөрийгөө хөгжүүлэх боломж нэмэгдсэн зэрэг олон давуу талууд байсан. Цахим сургалтын үйл ажиллагаанд оюутнуудтай амьд харьцаа үүсгэхгүй, дадлагын хичээлийг гардан хийх боломжгүй байдаг нь хамгийн том сул тал байв.

Цаашид цахим хэрэглэгдэхүүнтэй ажиллах болон хэлний мэдлэгээ нэмэгдүүлэн сургууль орчны интернет холболтоо сайжруулж, сургалтын е-контент бэлтгэн гадаад болон дотоодын суралцагчдаар сургалтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх боломж байна гэж үзлээ.

Цахим сургалтын явцад үүсч болох гол аюул нь дадлага хичээлийг гардан хийлгэх боломжгүйгээс дадлагажаагүй мэргэжилтэн бэлтгэх, мэдлэгийг бодитоор үнэлэх боломж хязгаарлагдах, хандлага төлөвшөөгүй мэргэжилтгүүд бэлтгэгдэх юм. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Цахим сургалтын SWOT үнэлгээ

Боловсруулсан материалыг давтан ашиглах	90.9	95.5	Оюутантай амьд харьцаа үүсгэхгүй
Цахим хэрэглэгдэхүүний шинэ мэдлэгийг олгосон	86.4	68.2	Хичээл бэлтгэхэд их хугацаа зарцуулсан
Хаанаас ч хичээлээ удирдах боломжтой	95.5	72.7	Бодит дадлага туршилт хийх боломжгүй
Цаг хугацааны хувьд уян хатан	68.2	77.3	Интернет холбоо, тоног төхөөрөмж хангалтгүй
Хөл хорионы үед хичээлийн жил алдалгүй суралцах	100	54.5	Цахим ном сурах бичиг хангалтгүй
Цахимаар суралцах шинэ сувгууд нээгдсэн	90.9	50	Цахим хэрэглэгдэхүүн хэлний мэдлэг хангалтгүй
Цахим сургалтын тоног төхөөрөмж сайжирсан	40.9	40.9	Хичээлд хамрагдаагүй оюутны голч буурсан
Цахим сургалтын давуу тал	S	W	Цахим сургалтын сул тал
Цахим сургалтын боломж	O	T	Цахим сургалтын аюул
Цахим ном эх сурвалжийг ашиглахад хялбар болгох	63.6	90.9	Сургалтын явцад бодит мэдлэгийг үнэлэх боломжгүй
Интернет холболтыг сайжруулах	77.3	77.3	Дадлагын хичээлийг бодитоор хийлгэхгүй тул дадлагажаагүй мэргэжилтэн бэлтгэх
Сургалтын Е-контент бэлтгэх	81.8	77.3	Амьд харилцаа үүсээгүй тул оюутны хандлага төлөвшөөгүй
Сургалтыг гадаад оюутнуудаар өргөжүүлэх	50	27.3	Сургалтын чанар буурсан тул чанаргүй мэргэжилтэн бэлтгэх
Цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх мэдлэгээ нэмэгдүүлэх	86.4		
Гадаад хэлний мэдлэгээ нэмэгдүүлэх	77.3		

Танхимын сургалтаар дадлагын хичээлийг мэргэжлийн кабинет болон лабораторид удирдан явуулснаар багш суралцах үйл ажиллагааг өөрийн биеэр хянаж, үнэлгээг илүү бодитоор үнэлэх давуу талуудтай.

Манай сургуулийн хувьд эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн сургалтын зарим хэрэглэгдэхүүн, бодис урвалж, тоног төхөөрөмж дутуу байгаа нь танхимын сургалтын гол сул тал болж байна.

Цаашид танхимын сургалтад сургалтын зарим хэрэглэгдэхүүн, бодис урвалж, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, багш нарын заах ур чадварыг сайжруулснаар сайн мэргэжилтэн бэлтгэх боломжтой. Танхимын сургалтын гол аюул нь багшаас хэт хамааралтай болох, орон нутагт байрладагтай холбоотой оюутны тоо буурах зэрэг болно. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Танхимын сургалтын SWOT үнэлгээ

Сургалтын чанар, стандарт хангалт сайн байдаг	68.2%	72.7%	Зарим хэрэглэгдэхүүн, бодис урвалж, тоног төхөөрөмж дутуу
Дадлага хичээлийг бодитоор хийх боломжтой	95.5%	18.2%	Оюутны бие даан суралцах чадварт сөрөг нөлөөтэй
Суралцах үйл ажиллагааг биеэр хянах боломжтой	90.9%	50%	Мэргэжил дээшлүүлэх сургалтуудад явж суралцах боломж дутмаг
Үнэлгээг үнэн бодитой хийх боломжтой	86.4%	45.5%	Мэргэжлийн хувьд хөгжих боломж муу
Танхимын сургалтын давуу тал	S	W	Танхимын сургалтын сул тал
Танхимын сургалтын боломж	O	T	Танхимын сургалтын аюул
Хэрэглэгдхүүн, урвалж, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	72.7%	57.1%	Цахим хэрэглэгдэхүүний хөгжлөөс хоцрох
Багш нарын заах арга, ур чадвар сайжрах	72%	71.4%	Багшаас хэт хамааралтай болох
Оюутны ур чадварыг бодитоор сайжруулах	86.4%	71.4%	Суралцагчийн тоо буурч байгаа
Төгсөгчдийг илүү чанаржуулах	81.8%	52.4%	Боловсон хүчний дутагдалд орох

Хэлцэмж: Танхим болон цахим хосолсон сургалт нь Баруун Европын орнуудад 20-оод жилийн өмнөөс хэрэгжиж эхэлсэн ч одоог хүртэл дээд боловсролын салбарт шинэлэг хэвээр байна.[3] Онлайн болон уламжлалт орчинг хослуулан сургах нь боломжит олон аргыг хооронд нь агуулгаар нь холбох, оюутан төдийгүй багш хооронд харилцааг дэмжих боломжтой сургалтын хэлбэр хэмээн зарим эрдэмтэд онцлон дурьдсан байдаг.[7]

Midwestern их сургуулийн багш нарын судалгаагаар хосолсон сургалтыг явуулахад 1. цаг хугацаа их шаардагддаг, 2. багш, оюутны харилцаа хөндийрдөг, 3. техникийн асуудал гэсэн гурван саад бэрхшээлтэй тулгарсан байна. Тухайлбал тохирсон агуулга бэлтгэн, хөгжүүлэхэд жил гаруй хугацаа зарцуулсан нь эхний бэрхшээл байв. Мөн түүнчлэн танхимд явуулах нарийн төвөгтэй дасгалуудыг боловсруулах нь судлаачдын хувьд цаг хугацаа шаардсан өөр нэг ажил байв. Сонирхолтой, бодит дасгалуудыг бий болгох нь зөвхөн сурах бичгээс жишээ авахаас огт өөр зүйл байсан тул багш, ажилчдаас багагүй хүчин чармайлт шаардсаныг онцолсон байна. Хоёрдахь бэрхшээл нь оюутнуудтай холбоо тогтоохгүй байх явдал байв. Оюутнуудад хэт их ачаалал үүсгэхгүйн тулд онлайн дасгал даалгаварт зарцуулах цаг хугацаанаас хамаарч оюутнуудтай харилцах цагийг бууруулсан нь эмх цэгц, зохион байгуулалттай сургалтын арга барилыг илүүд үздэг зарим оюутнуудад сул тал байж болох юм. Гурав дахь бэрхшээл нь, шинэ сургалтын дизайн, онлайн агуулгыг хөгжүүлэх, видео лекц засах, асуулт хариултын тест хийх зэрэг сургалтын бэлтгэл ажилд техник технологийн өндөр мэдлэгтэй баг хамт олон шаардлагатай болж байсан гэжээ.[6] Бид цахим сургалтын SWOT үнэлгээг хийж үзэхэд дээрх 3 асуудал манай багш нарт адил тулгарсан байна.

Манай орны хувьд анх МУИС Массачусетсийн Технологийн их сургуультай хамтран хосолсон сургалтын аргыг туршсан гэсэн мэдээ байдаг ч сургалтын үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хомс байна.[4-5] Манай улсын бүх шатны боловсролын байгууллагууд Ковид19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулсан. Үүнтэй холбогдуулан судлаач Ж.Төгсөө нарын хийсэн “Танхим болон цахим сургалтын онол арга зүйн асуудал” судалгааны үр дүнгээс харахад оюутнууд хичээлээ цахим, танхим хосолсон байдлаар авахыг хүссэн үр дүн гарчээ. Мөн судалгаанд хамрагдсан багш оюутнууд хичээлийг 100% цахим хэлбэрээр явуулах нь тохиромжгүй гэж үзжээ.[5] Цаашид танхим, цахим хосолсон сургалтыг нэвтрүүлэхэд онол, практикийн судалгааг олон талаас нь хийх, боловсролын суурь зарчимд түшиглэсэн туршилт сургалтууд хэрэгжүүлэх, судлагдахууны онцлогоос шалтгаалан сургалтын хэлбэрийг сонгоход шинжлэх ухааны үндэслэлтэй хандах, зохион байгуулалттай үйл ажиллагаа шаардлагатай болох нь харагдаж байна.

Дүгнэлт:

1. Танхимын болон цахим сургалт аль аль нь өөрийн гэсэн давуу болон сул талуудтай бөгөөд SWOT үнэлгээ хийснээрээ цахим болон танхимын сургалтыг хослуулан ашиглахад цаг хугацааны хувьд уян хатан, орон зай харгалзахгүй суралцах, эдийн засгийн хувьд хэмнэлттэй, дахин давтан ашиглах зэрэг боломжууд байгаа тогтоолоо. Сургалтыг цахим хэлбэрээр явуулснаар гадаад оюутнуудыг элсүүлэн суралцуулах боломж нээгдэнэ гэж үзэж байна.
2. Гардан ур чадвар шаардсан хичээлийг зайлшгүй танхимаар удирдан явуулах нь суралцагчдад бодит ур чадварыг эзэмшүүлэх, үнэлгээг бодитой хийн чадварлаг мэргэжилтнүүд бэлтгэх боломж олгож байна. Анагаахын мэргэжилтан бэлтэх сургалтад дан цахим хэлбэрийн сургалт тохиромжгүй бөгөөд танхим болон цахим сургалтыг зохистойгоор хослуулан явуулах нь илүү үр дүнтэй.

Ном зүй:

1. *Salcedo, C. S. “Comparative Analysis Of Learning Outcomes In Face-To-Face Foreign Language Classes” Vs. Language Lab And Online. Journal of College Teaching & Learning –February 2010 Volume 7, Number 2 (page 43-53)*
2. *Aliye Karabulut Ilgu. “Comparative Analysis Of Learning Outcomes In Face-To-Face Foreign Language Classes” American Society for Engineering Education, 2015*
3. *Dziuban, C. D., Hartman, J. L., and Moskal, P. D. «Blended Learning.» edited by Center for Applied Research EDUCAUSE, 2004, accessed June 12, 2014 https://net.educause.edu/ir/library/pdf/erb0407.pdf*
4. *Olapiriyakul, Kamolbhan; Scher, Julian M. “A Guide to Establishing Hybrid Learning Courses: Employing Information Technology to Create a New Learning Experience, and a Case*

Study"Internet and Higher Education, 2006. v9 n4 p287-301
5. Ч. Лодойравсал. "Сурахад суралцах нь" Улаанбаатар 2019 он. Хуудас 81
6. Ж.Төгсөө, Т.Оюун-Эрдэнэ, С.Сайнзаяа " Танхим болон цахим хосолсон сургалтын онол аргазүйн зарим асуудал" 2021 он
7. Qi, L., & Tian, A. Design and Application of Hybrid Learning Platform Based on Joomla. In M. Zhou, & H. Tan (Eds.), (2011). Advances in Computer Science and Education Applications (pp. 549-556)
8. Sameer M. AlNajd. "HYBRID LEARNING IN HIGHER EDUCATION" Society for Information Technology & Teacher Education International Conference March 2014.

A comparative study of SWOT assessment of classroom and e-teaching in Dornogobi Medical school

Enkhmaa Sh[1], Munkhtuya G[1]

[1]Dornogobi Medical school, MNUMS
E-mail: enkhmaa@mnums.edu.mn, Tel: +976-91002989

Background: Until the middle of the 20th century, the time when the world received education services mainly in the form of classroom training is behind us. In the 21st century, in the era of rapid development of information technology, not only education but also all areas of society use the Internet and electronic platforms to conduct training and any activities, opportunities are emerging. Due to the trends of global development and the current situation, the need to introduce a combination of electronic and classroom based on modern information technology in educational services at all levels is increasing.
Aim: A comparative SWOT assessment of classroom and e-learning
Materials and Methods: The survey was conducted using the Google Form survey platform from 22 teachers of the Dornogobi Medical School, MNUMS.
Results: It was very important to notify learning activities in the course of an e-learning SWOT rating. In addition to the teacher that has been able to keep the classified and developed materials to keep the new study and e -Treme new knowledge of e -Treme new learning, e -Treme new learning. Do not create a living ratio with students in e-learning activities, you are the biggest weakness.
The teaching practices of the classroom training and labs have an advantage of the teacher to review the teacher to review the actual reality.
Conclusion:

1. Classroom and e-learning both have their advantages and disadvantages. From the SWOT analysis, it is concluded that there is the following opportunity to use a combination of online and classroom training.Conducting theoretical lectures and seminars in electronic form is flexible and economical in terms of time, economical and reusable because it can be learned from anywhere.In the future, conducting e-learning may be an opportunity to expand the scope of training with international students.
2. Conducting courses requiring hands-on skills in the classroom provides an opportunity for students to acquire real skills and prepare competent professionals through realistic assessment.Only electronic training is not suitable for medical specialist training

Keywords: Blended learning, e-tools, advantages and disadvantages